



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/192

Улаанбаатар хот

**Дүүргийн хэмжээнд Төрийн
байгууллагын ажлын зохион байгуулалт,
архив албан хэрэг хөтлөлтийн улсын
үзлэг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны "Улсын үзлэг зохион байгуулах тухай" 23 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн "Улсын үзлэг зохион байгуулах тухай" А/1220 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэгийг дүүргийн хэмжээнд 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс 10 дугаар сарын 23-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2.Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг дүүргийн хэмжээнд зохион байгуулах дүүргийн салбар комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зохион байгуулах ажлын хэсгийг хоёрдугаар, үзлэгт хамрагдах байгууллагуудын жагсаалт, хуваарийг гуравдугаар, үйл ажиллагаанд шаардагдах зардлын төсвийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3.Улсын үзлэгт бэлтгэх байгууллагын комиссыг байгууллага бүр дотооддоо байгуулж, үзлэгийн бэлтгэл зохион байгуулалтыг сайтар хангаж дүгнүүлэх, дотооддоо урьдчилсан үзлэг зохион байгуулж, салбар комиссоос үзлэг явуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг үзлэгт хамрагдах нийт байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

4.Улсын үзлэг явуулахад шаардагдах 2,593,800 (Хоёр сая таван зуун ерэн гурван мянга найман зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5.Улсын үзлэгийн хүрээнд зохион байгуулах нэгдсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган гүйцэтгэлд хяналт тавьж, ажиллах, үзлэгийн нэгдсэн дүн мэдээ болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, амжилттай дүн үзүүлсэн байгууллагын удирдлага ажилтнуудыг шагнаж урамшуулах, хангалтгүй дүгнэгдсэн байгууллагын удирдлагуудад зохих арга хэмжээг төлөвлөж, дүүргийн Удирдлагын зөвлөлийн хуралд тайлагнаж ажиллахыг салбар комиссын дарга (Л.Санжийжамц)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны дүгээр сарын-ны өдрийн
А/192 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
АРХИВ АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН УЛСЫН ҮЗЛЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ДҮҮРГИЙН САЛБАР
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын
дарга:
Комиссын орлогч
дарга:
Гишүүд:

Засаг даргын Тамгын газрын дарга

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн
бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга
(зөвшилцсөнөөр)

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа
өргөдөл, гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн

Засаг даргын Тамгын газрын Тогтоол шийдвэрийн
биелэлт хариуцсан мэргэжилтэн

Засаг даргын Тамгын газрын Хүний нөөц, төрийн
албан хаагчийн ёс зүй, шагнал хариуцсан
мэргэжилтэн

Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл технологи,
дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн

Засаг даргын Тамгын газрын Архивын зааварлагч,
арга зүйч

Засаг даргын Тамгын газрын Албан хэрэг
хөтлөлт хариуцсан эрхлэгч

Нарийн бичгийн
дарга:

Архивын хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн
... дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ,
АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН УЛСЫН ҮЗЛЭГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1 дүгээр ажлын хэсэг

Ажлын хэсгийн

ахлагч: Л.Санжийжамц

Гишүүд: Б.Цогжавхлан

А.Золзаяа

О.Оюуномин

Засаг даргын Тамгын газрын дарга

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Засаг даргын Тамгын газрын Хүний нөөц, төрийн
албан хаагчийн ёс зүй, шагнал хариуцсан мэргэжилтэн

Засаг даргын Тамгын газрын Архивын зааварлагч,
арга зүйч

2 дугаар ажлын хэсэг

Ажлын хэсгийн

ахлагч: М.Давааням

Гишүүд: Н.Өлзийцэцэг

Б.Одбаяр

Б.Гэрэлцолмон

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Нарийн
бичгийн дарга бөгөөд Ажлын албаны
дарга /зөвшилцсөнөөр/

Архивын хэлтсийн даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

Засаг даргын Тамгын газрын Тогтоол шийдвэрийн
биелэлт хариуцсан мэргэжилтэн

Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа
өргөдөл, гомдол хариуцсан Ахлах мэргэжилтэн

3 дугаар ажлын хэсэг

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Отгонжаргал

Гишүүд: Ц.Мягмарсүрэн

Б.Оюунгэрэл

Н.Батболд

Төрийн захиргааны удирдлагын хэлстийн дарга

Санхүү, төрийн сангийн хэлстийн дарга

Засаг даргын Тамгын газрын Албан хэрэг хөтлөлт
хариуцсан эрхлэгч

Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл технологи,
дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны ...09 дүгээр сарын ...18-ны өдрийн
... дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АРХИВ АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН
УЛСЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ, ХУВААРЬ

Д/д	Ажлын хэсэг	Үзлэгт хамрагдах байгууллагын нэр	Хугацаа
1.	1 дүгээр ажлын хэсэг	Дотоод аудитын алба	2025.10.14
2.		Нийгмийн даатгалын газар	2025.10.15
3.		Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс	2025.10.16
4.		1 дүгээр хороо	2025.10.17
5.		2 дугаар хороо	2025.10.20
6.		Татварын хэлтэс	2025.10.21
7.		Эрүүл мэндийн төв	2025.10.22
8.		Биеийн тамир, спортын хороо	2025.10.23
9.	2 дугаар ажлын хэсэг	Худалдан авах ажиллагааны алба	2025.10.14
10.		Нийслэлийн ерөнхий боловсролын 91 дүгээр сургууль	2025.10.15
11.		Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ	2025.10.16
12.		Нийслэлийн ерөнхий боловсролын 94 дүгээр сургууль	2025.10.17
13.		"Илч-орд" ОНӨААТҮГ	2025.10.20
14.		Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв	2025.10.21
15.		Багахангай "Тохижилт" ОНӨААТҮГ	2025.10.22
16.		Ахмадын хороо	2025.10.23
17.	3 дугаар ажлын хэсэг	Онцгой байдлын хэлтэс	2025.10.14
18.		Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэс	2025.10.15
19.		Боловсролын хэлтэс	2025.10.16
20.		Соёлын ордон	2025.10.17
21.		Нийслэлийн хүүхдийн 44 дүгээр цэцэрлэг	2025.10.20
22.		Нийслэлийн хүүхдийн 207 дугаар цэцэрлэг	2025.10.21
23.		Газар зохион байгуулалтын алба	2025.10.22

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 09 дугаар сарын 18-ны өдрийн
А/192 дугаар захирамжийн дөрөвдүгээр хавсралт

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АРХИВ АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН
УЛСЫН ҮЗЛЭГТ ЗАРЦУУЛАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Амжилттай дүгнэгдсэн байгууллага, албан тушаалтанд олгох шагналын зардал					
1	1-р байр	ш	1	600,000	600,000
2	2-р байр	ш	1	500,000	500,000
3	3-р байр	ш	1	400,000	400,000
4	Жааз	ш	3	25,000	75,000
5	Өргөмжлөл	ш	3	100,000	300,000
	Дүн				1,875,000
Салбар комиссын зардал					
1	Шатахууны зардал	л	60	2780	166,800
2	Бичгийн цаас	боодол	6	22.000	132,000
3	Каноны хор	ш	2	60.000	120,000
4	Бусад зардал	-	-	-	300,000
	Нийт дүн				2,593,800